

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/136/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: [saranchimegts@audit.gov.mn](mailto:saranchimegts@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: [auditulziit@gmail.mn](mailto:auditulziit@gmail.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НД	Нийгмийн даатгал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/107  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
О.БОЛОРТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 сарын 21-ны өдрийн 241 тоот тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” албан хаагчдын цалингийн хэмжээнд өөрчлөлт орсон байна.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

019020198

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>85,215,705.36</b>	<b>77,146,122.31</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>23,310,236.11</b>	<b>22,189,295.60</b>
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>23,310,236.11</b>	<b>22,189,295.60</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>23,310,236.11</b>	<b>22,189,295.60</b>
<b>31</b>	Төрийн сангийн харилцах	<b>23,310,236.11</b>	<b>22,189,295.60</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		<b>6,862,340.00</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		6,862,340.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>61,905,469.25</b>	<b>48,094,486.71</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>42,427,500.35</b>	<b>32,869,647.51</b>
35110	Тусгай зориулалттай материал	26,410,410.79	20,597,626.18
35130	Эм боох материал	16,017,089.56	12,272,021.33
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>19,477,968.90</b>	<b>15,244,839.20</b>
35410	Бичиг хэргийн материал	553,800.00	107,300.00
35420	Аж ахуйн материал	16,990,756.40	14,329,380.60
35460	Хүнсний материал	1,933,412.50	788,158.60
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,530,681,144.67</b>	<b>1,557,398,689.10</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,530,681,144.67</b>	<b>1,557,398,689.10</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,527,611,144.71</b>	<b>1,550,651,689.18</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,411,135,102.00	1,411,135,102.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(67,994,756.65)	(91,207,660.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	44,257,074.00	49,770,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(19,257,074.04)	(13,295,000.08)
39205	Машин тоног төхөөрөмж	159,620,712.16	226,260,991.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,839,893.17)	(73,831,824.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,050,759.79	51,481,383.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,574,179.38)	(10,874,702.18)
39217	Номын фонд	1,213,400.00	1,213,400.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>3,069,999.96</b>	<b>6,746,999.92</b>
39301	Программ хангамж	105,000.00	105,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(35000.04)	(70,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,000,000.00	6,712,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,615,896,850.03</b>	<b>1,634,544,811.41</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,615,896,850.03</b>	<b>1,634,544,811.41</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,615,896,850.03</b>	<b>1,634,544,811.41</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	224,674,344.73	224,674,344.73
51101	Өмч:-төрийн	224,674,344.73	224,674,344.73
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,390,587,787.62</b>	<b>1,409,235,749.00</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	<b>1,390,587,787.62</b>	<b>1,390,587,787.62</b>
51220	Тайлант үеийн үр дүн		18,647,961.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	634,717.68	634,717.68
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,615,896,850.03</b>	<b>1,634,544,811.41</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,835,549,560.33</b>	<b>617,781,915.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,409,128,330.33</b>	<b>120,838,292.04</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,409,128,330.33</b>	<b>120,838,292.04</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,409,128,330.33	120,838,292.04
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,409,128,330.33	96,792,902.62
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		24,045,389.42
<b>1310</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>30,528,000</b>	<b>64,429,500</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллагаас/	30,528,000	64,429,500
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>250,000</b>	<b>10,150,000</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	250,000	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		10,150,000
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>395,643,230.00</b>	<b>422,364,123.51</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	395,643,230.00	422,364,123.51
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>488,597,334.96</b>	<b>599,133,954.17</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>488,597,334.96</b>	<b>599,133,954.17</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>480,062,799.96</b>	<b>598,002,393.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>267,040,183.75</b>	<b>310,755,860.21</b>
210101	Үндсэн цалин	180,454,273.20	197,439,648.17
210102	Нэмэгдэл	59,973,497.29	92,850,998.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,487,992.00	3,588,000.00
210104	Урамшуулал	23,124,421.26	16,877,213.19
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>34,460,990.88</b>	<b>40,186,829.18</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,364,125.40	27,874,286.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,664,348.68	3,318,881.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,101,238.94	2,834,725.89
210204	Ажилгүйдлийн даатгал	484,661.66	534,778.61
210205	Эрүүл мэндийн даатгал	4,846,616.20	5,624,156.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,533,465</b>	<b>62,972,939.31</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,134,323.00	5,641,995.31
210302	Түлш, халаалт	26,399,142.00	57,330,994.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,588,828.20</b>	<b>35,732,974.38</b>
210401	Бичиг хэрэг	1,498,500.00	1,104,300.00
210402	Тээвэр, шатахуун	18,501,775.00	15,912,320.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	523,800.00	518,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,827,600.00	1,741,950.00

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210408	Бараа материал акталсны зардал	1,237,153.20	16,455,604.38
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>57,667,093.45</b>	<b>44,943,435.38</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	47,455,120.95	36,266,891.48
210502	Хоол, хүнс	10,211,972.50	8,676,543.90
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,142,600.00</b>	<b>1,141,500.00</b>
210604	Урсгал засвар	2,142,600.00	1,141,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,320,700.00</b>	<b>1,596,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,320,700.00	1,596,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>65,308,938.68</b>	<b>100,672,855.02</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,712,320.45	29,837,496.83
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,596,618.23	70,835,358.19
<b>27</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,534,535.00</b>	<b>1,131,560.69</b>
	Бусад урсгал шилжүүлэг	<b>8,000,000.00</b>	<b>1,100,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000,000.00	1,100,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт</b>	<b>534,535.00</b>	<b>31,560.69</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	534,535.00	31,560.69
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,346,952,225.37</b>	<b>18,647,961.38</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>379,234.77</b>	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	379,234.77	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(379,234.77)</b>	
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,346,572,990.60</b>	<b>18,647,961.38</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>496,885,030.00</b>	<b>490,081,283.51</b>
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>496,885,030.00</b>	<b>490,081,283.51</b>
<b>1310</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>30,528,000</b>	<b>64,429,500</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллагаас/	30,528,000	64,429,500
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>250,000.00</b>	<b>10,150,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	250,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		10,150,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>466,107,030.00</b>	<b>415,501,783.51</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	466,107,030.00	415,501,783.51
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>457,559,355.18</b>	<b>490,442,224.02</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>457,559,355.18</b>	<b>490,442,224.02</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>449,024,820.18</b>	<b>489,310,663.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>267,040,183.75</b>	<b>310,755,860.21</b>
210101	Үндсэн цалин	180,454,273.20	197,439,648.17
210102	Нэмэгдэл	59,973,497.29	92,850,998.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,487,992.00	3,588,000.00
210104	Урамшуулал	23,124,421.26	16,877,213.19
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>34,460,990.88</b>	<b>40,186,829.18</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,364,125.40	28,092,536.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,664,348.68	3,268,881.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,101,238.94	2,644,314.39
210204	Ажилгүйдлийн даатгал	484,661.66	535,178.61
210205	Эрүүл мэндийн даатгал	4,846,616.20	5,645,917.91
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,843,465.00</b>	<b>63,247,939.31</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,134,323.00	5,641,995.31
210302	Түлш, халаалт	26,399,142.00	57,330,994.00
210303	Цэвэр, бохир ус	310,000.00	275,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,633,275.00</b>	<b>18,823,520.00</b>
210401	Бичиг хэрэг	1,706,300.00	656,300.00
210402	Тээвэр, шатахуун	18,501,775.00	15,912,320.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	523,800.00	518,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,901,400.00	1,736,100.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>65,096,460.50</b>	<b>41,472,844.63</b>

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,291,000.50	34,384,554.63
210502	Хоол, хүнс	9,805,460.00	7,088,290.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,823,500.00</b>	<b>1,168,150.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,715,000.00	18,150.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,458,500.00	
210604	Урсгал засвар	4,650,000.00	1,150,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,320,700.00</b>	<b>1,596,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,320,700.00	1,596,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,483,300.00</b>	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,483,300.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,322,945.05</b>	<b>12,059,520.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,322,945.05	12,059,520.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,534,535.00</b>	<b>1,131,560.69</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,000,000.00</b>	<b>1,100,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000,000.00	1,100,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт</b>	<b>534,535.00</b>	<b>31,560.69</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	534,535.00	31,560.69
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>39,325,674.82</b>	<b>(360,940.51)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>39,575,570.00</b>	<b>760,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>39,575,570.00</b>	<b>760,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>39,575,570.00</b>	<b>760,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	39,575,570.00	760,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(39,575,570.00)</b>	<b>(760,000.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(249,895.18)</b>	<b>(1,120,940.51)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>23,560,131.29</b>	<b>23,310,236.11</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>23,310,236.11</b>	<b>22,189,295.60</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>224,674,344.73</b>	<b>634,717.68</b>	<b>44,014,797.02</b>	<b>269,323,859.43</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>224,674,344.73</b>	<b>634,717.68</b>	<b>44,014,797.02</b>	<b>269,323,859.43</b>
Тайлант үеийн үр дүн			1,346,572,990.60	1,346,572,990.60
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>224,674,344.73</b>	<b>634,717.68</b>	<b>1,390,587,787.62</b>	<b>1,615,896,850.03</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн</b>	<b>224,674,344.73</b>	<b>634,717.68</b>	<b>1,390,587,787.62</b>	<b>1,615,896,850.03</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			18,647,961.38	18,647,961.38
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>224,674,344.73</b>	<b>634,717.68</b>	<b>1,409,235,749</b>	<b>1,634,544,811.41</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>23,310,236.11</b>	<b>(23,310,236.11)</b>	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>559,760,300.00</b>	<b>491,202,224.02</b>	<b>68,558,075.98</b>	<b>87.8%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>559,760,300.00</b>	<b>491,202,224.02</b>	<b>68,558,075.98</b>	<b>87.8%</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>550,760,300.00</b>	<b>490,070,663.33</b>	<b>60,689,636.67</b>	<b>89.0%</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	<b>359,106,100.00</b>	<b>310,755,860.21</b>	<b>48,350,239.79</b>	<b>86.5%</b>
Үндсэн цалин	225,091,000.00	197,439,648.17	27,651,351.83	87.7%
Нэмэгдэл	83,951,600.00	92,850,998.85	(8,899,398.85)	110.6%
Унаа хоолны хөнгөлөлт	3,880,800.00	3,588,000.00	292,800.00	92.5%
Урамшуулал	46,182,700.00	16,877,213.19	29,305,486.81	36.5%
<b>Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл</b>	<b>41,400,400.00</b>	<b>40,186,829.18</b>	<b>1,213,570.82</b>	<b>97.1%</b>
Тэтгэврийн даатгал	28,151,800.00	28,092,536.60	59,263.4	99.8%
Тэтгэмжийн даатгал	3,312,700.00	3,268,881.67	43,818.33	98.7%
ҮОМШӨ-ний даатгал	2,650,000.00	2,644,314.39	5,685.61	99.8%
Ажилгүйдлийн даатгал	662,100.00	535,178.61	126,921.39	80.8%
Эрүүл мэндийн даатгал	6,623,800.00	5,645,917.91	977,882.09	85.2%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>63,879,500.00</b>	<b>63,247,939.31</b>	<b>631,560.69</b>	<b>99.0%</b>
Гэрэл, цахилгаан	5,959,800.00	5,641,995.31	317,804.69	94.7%
Түлш, халаалт	57,319,700.00	57,330,994.00	(11,244.00)	100.0%
Цэвэр, бохир ус	600,000.00	275,000.00	325,000.00	45.8%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,840,900.00</b>	<b>18,823,520.00</b>	<b>5,017,380.00</b>	<b>79.0%</b>
Бичиг хэрэг	1,137,800.00	656,300.00	481,500.00	57.7%
Тээвэр, шатахуун	20,292,000.00	15,912,320.00	4,379,680.00	78.4%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	675,000.00	518,800.00	156,200.00	76.9%
Хог хаягдал зайлуулах, мэрэгчдийг устгал	1,736,100.00	1,736,100.00		100.0%
<b>Норматив зардал</b>	<b>44,464,200.00</b>	<b>41,472,844.63</b>	<b>2,991,355.37</b>	<b>93.3%</b>
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,367,000.00	34,384,554.63	2,982,445.37	92.0%
Хоол, хүнс	7,097,200.00	7,088,290.00	8,910.00	99.9%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,150,000.00</b>	<b>1,928,150.00</b>	<b>1,221,850.00</b>	<b>61.2%</b>
Багаж, техник хэрэгсэл	2,000,000.00	778,150.00	1,221,850.00	38.9%
Урсгал засвар	1,150,000.00	1,150,000.00		100.0%
<b>Томилот, зочны зардал</b>	<b>2,839,500.00</b>	<b>1,596,000.00</b>	<b>1,243,500.00</b>	<b>56.2%</b>
Дотоод албан томилолт	2,839,500.00	1,596,000.00	1,243,500.00	56.2%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,079,700.00</b>	<b>12,059,520.00</b>	<b>20,180.00</b>	<b>99.8%</b>

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	12,079,700.00	12,059,520.00	20,180.00	99.8%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,000,000.00</b>	<b>1,131,560.69</b>	<b>7,868,439.31</b>	<b>12.6%</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,000,000.00</b>	<b>1,100,000.00</b>	<b>7,900,000.00</b>	<b>12.2%</b>
Нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,000,000.00	1,100,000.00	7,900,000.00	12.2%
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		<b>31,560.69</b>	<b>(31,560.69)</b>	
Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		31,560.69	(31,560.69)	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>559,760,300.00</b>	<b>490,081,283.51</b>	<b>69,679,016.49</b>	<b>87.6%</b>
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>65,029,500.00</b>	<b>64,429,500.00</b>	<b>600,000.00</b>	<b>99.1%</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллагаас/	65,029,500.00	64,429,500.00	600,000.00	99.1%
<b>НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>484,730,800.00</b>	<b>415,501,783.51</b>	<b>69,229,016.49</b>	<b>85.7%</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	484,730,800.00	415,501,783.51	69,229,016.49	85.7%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>10,000,000.00</b>	<b>10,150,000.00</b>	<b>(150,000.00)</b>	<b>101.5%</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	10,150,000.00	(150,000.00)	101.5%
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>23,310,236.11</b>	<b>(23,310,236.11)</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>22,189,295.60</b>	<b>(22,189,295.60)</b>	
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>19</b>	<b>19</b>		<b>100.0%</b>
Удирдах ажилтан	1	1		100.0%
Гүйцэтгэх ажилтан	10	10		100.0%
Үйлчлэх ажилтан	8	8		100.0%

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны 12 сард ашиглалтад орсон 15 хүний ортой, цэвэр бохир ус, дулааны системд холбогдсон барилгад эмнэлгийн тусламж үйлчилгээг 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр үзүүлж байна.

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төв нь эрхэм зорилгоо “Сумын хүн амыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд сургах, бие бялдрын өв тэгш хөгжлийг хангаж, эмнэлгийн тусламж үйлчилгээг, ёс зүйтэй орчинд цаг алдалгүй, жигд хүртээмжтэй, чанартай, соёлтой үзүүлэх” гэж тодорхойлжээ.

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төв нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах”
- Эрүүл мэндийн яамны сайдын 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/139 тоот “Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг шинжилгээ оношилгоо”-г зохион байгуулах журам

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2023 оны санхүүгийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу 2022, 2023 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэсэн бөгөөд 95,0 хувийн үнэлгээтэй үнэлүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай бүрэн нийцэхгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,647.9 мянган төгрөгөөр буюу 1,2 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	23,310.2	22,189.2	(1,121.0)
Авлага		6,862.3	(6,862.3)
Бараа материал	61,905.5	48,094.5	(13,811.0)
Үндсэн хөрөнгө	1,530,681.1	1,557,398.7	26,717.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,615,896.8</b>	<b>1,634,544.7</b>	<b>(18,647.9)</b>
Засгийн газрын хувь оролцоо	224,674.3	224,674.3	
Хуримтлагдсан үр дүн	1,390,587.8	1,409,235.7	(18,647.9)
Дахин үнэлгээний нэмэгдэл	634.7	634.7	
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,615,896.8</b>	<b>1,634,544.7</b>	<b>(18,647.9)</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, данс байна. Энэ нь авлагын дансны үлдэгдэл 6,862.3 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагын дүн өссөнөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 13,811.0 мянган төгрөгөөр буурсан бол Төв аймгийн Эрүүл мэндийн газраас 23,157.4 мянга, иргэн, аж ахуйн нэгжээс 888.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө данс 2023 онд тээврийн хэрэгсэл 19,770.0 мянган төгрөг, машин тоног

төхөөрөмж 66,640.3 мянган төгрөг, тавилга эд хогшил 7,430.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 14,257.1 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 760.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 19,770.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 66,640.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 6,670.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,634,544.7 мянган төгрөг болж 18,647.9 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 402,154.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 157,606.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 559,760.9 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 402,154.2 мянган төгрөгөөс 3 удаа тодотгол хийж орон нутгийн төсвөөс 65,029.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын газраас 484,730.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд 10,000.0 мянган төгрөг, нийт 559,760.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 559,760.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 31.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 491,202.2 мянган төгрөг буюу 87,8 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ				
1.1	80111-Төрийн байгууллагуудын тогтмол зардал	65,029.5	64,429.5	600.0	99.0%
1.2	80302-Нэг хүнд ногдох нормативаар тооцсон.	334,702.0	276,474.2	58,227.8	82.6%
1.3	81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	126,718.5	105,438.5	21,280.0	83.2%
1.4	83603- Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	33,310.3	33,130.3		100.0%
	<b>Дүн</b>	<b>559,760.3</b>	<b>479,472.5</b>	<b>80,107.8</b>	<b>99.9%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төв тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 1,450.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 23,112.0 мянган төгрөгийн тээвэр шатахуун, 8,799.8 мянган төгрөгийн хоол хүнс, 6,815.0 мянган төгрөгийн бусад материал, нийт 40,176.8 мянган төгрөгийн барааг шууд худалдан авалтаар авахаар, 64,179.5 мянган төгрөгийн гэрээг шууд худалдан авах гэрээ байгуулахаар нийт 104,356.3 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 125,472.3 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн өссөн нь төсөв нэмэгдсэнтэй холбоотой байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 488,597.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,396.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн байдлын 75 хувиар буюу 5,496.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын орон тоог хэмнэх, хавсран ажиллах, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант онд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 48,350.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 5,017.4 мянган төгрөг, норматив зардал 2,991.3 мянган төгрөг, эд хогшил 1,221.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэн ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 159 мэдээллээс 158 мэдээллийг хуулийн хугацаандаа, 100,906.3 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" гэж заасныг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд байршуулах мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, хуулийн хугацаанд багтаан мэдээлж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

*Завсрын аудит хийгдээгүй болно.*

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 2 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	120.6	1	120.6	100%
Албан шаардлага	2	7,052.5	2	7,052.5	100%
Зөвлөмж	2	3,190.6	2	3,190.6	100%
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>10,363.7</b>	<b>5</b>	<b>10,363.7</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байна. Үүнээс үүдэн эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагын гүйлгээний хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүссэн асуудлыг дараагийн аудитаар авч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### Залруулсан алдаа

Аудитаар нийт 44,014.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup>илэрснээс аудитын явцад 44,014.8 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

#### Залруулсан алдаа

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл дүнг 44,014.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь, УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 126.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 126.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг зохих хууль тогтоомж журмын дагуу данс бүртгэлд тусгах зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Тайлант онд 1,100.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг олгохдоо 126.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-д "ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах, эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн суутган тооцоогүй татварыг холбогдох этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн асуудал.

#### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаарх анхны үнийг нөхсөн хөрөнгийг дахин үнэлэн данс бүртгэлд бүртгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаарх анхны үнээ бүрэн нөхсөн хөрөнгийг дахин ашиглахаар зохих дээд шатны байгууллагад албан тоот хүргүүлэн шийдвэрлэж данс бүртгэлд тусган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл зөрүүтэй илэрхийлсэн	1	44,014.8					1	44,014.8				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>44,014.8</b>					<b>1</b>	<b>44,014.8</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Тайлант онд 1,100.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй	1	126.5	1	126.5									

Төв аймгийн Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаарх анхны үнийг нөхсөн хөрөнгийг дахин үнэлэн данс бүртгэлд бүртгээгүй	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>126.5</b>	<b>1</b>	<b>126.5</b>			<b>1</b>	<b>-</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим системд 100,906.3 мянган төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй	1	100,906.3						1	100,906.3
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>100,906.3</b>						<b>1</b>	<b>100,906.3</b>